

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/37/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545

цахим хаяг: narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
4. Аудитын илрүүлэлт.....	10
4.1 Залруулсан алдаа.....	10
4.2 Төлбөрийн акт.....	11
4.3 Албан шаардлага	11
4.4 Зөвлөмж	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,654,035,820</u>	<u>2,679,778,225</u>
33	АВЛАГА	2,652,013,320	2,654,576,140
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,352,000	2,665,000
335	Бусад авлага	2,650,661,320	2,651,911,140
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,650,661,320	2,651,911,140
34	УРЬДЧИЛГАА	-	19,719,585
34600	Урьдчилж гарсан зардал	-	19,719,585
35	БАРАА МАТЕРИАЛ	2,022,500	5,482,500
354	Хангамжийн материал	2,022,500	5,482,500
35440	Түлш, шатах тослох материал	730,000	3,330,000
35470	Бусад хангамжийн материал	1,292,500	2,152,500
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,654,035,820</u>	<u>2,679,778,225</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>448,673,950</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	448,673,950	-
413	Өглөг	448,673,950	-
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	448,673,950	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,205,361,870</u>	<u>2,679,778,225</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,205,361,870	2,679,778,225
512	Хуримтлагдсан үр дүн	2,205,361,870	2,679,778,225
51210	Өмнөх үеийн үр дүн	2,354,510,301	2,432,009,870
51220	Тайлант үеийн үр дүн	(149,148,431)	247,768,355
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,654,035,820</u>	<u>2,679,778,225</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,181,171,230	1,483,016,725.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,956,730	182,320,575.52
120	Нийтлэг татварын бус орлого	33,956,730	182,320,575.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,956,730	182,320,575.52
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,956,730	182,320,575.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,147,214,500	1,300,696,150
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	363,027,000	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	363,027,000	

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	784,187,500	1,300,696,150
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,987,500	61,440,200
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	751,200,000	1,239,255,950
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,330,319,661	1,235,248,370.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,330,319,661	1,235,248,370.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,433,000	63,940,200
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,932,000	6,000,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000	5,500,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	932,000	2,000,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,501,000	57,940,200
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,869,000	34,955,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,632,000	22,985,200
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,301,886,661	1,171,308,170.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	869,582,887	401,996,078
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	869,582,887	401,996,078
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,391,761	182,320,575.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	65,391,761	182,320,575.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,850,063	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,850,063	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	349,061,950	586,991,517
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	349,061,950	586,991,517
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(149,148,431)	247,768,355
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(149,148,431)	247,768,355

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,205,361,870	2,205,361,870
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,205,361,870	2,205,361,870
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,205,361,870	2,205,361,870
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,205,361,870	2,205,361,870
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	226,648,000	226,648,000
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,432,009,870	2,432,009,870
D08	Тайлант үеийн үр дүн	239,718,770	247,768,355
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,671,728,640	2,679,778,225

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,530,433,180</u>	<u>2,059,766,905.52</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	383,218,680	182,320,575.52
120	Нийтлэг татварын бус орлого	383,218,680	182,320,575.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	383,218,680	182,320,575.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	349,261,950	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,956,730	182,320,575.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,147,214,500	1,877,446,330
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	363,027,000	576,750,180
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		576,750,180
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	363,027,000	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	784,187,500	1,300,696,150
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,987,500	61,440,200
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	751,200,000	1,239,255,950
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,530,433,180</u>	<u>2,059,766,905.52</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,530,433,180	2,059,766,905.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,164,437	65,440,200
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,663,437	7,500,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000	5,500,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,663,437	2,000,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,501,000	57,940,200
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,869,000	34,955,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,632,000	22,985,200
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,501,268,743	1,994,326,705.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,100,200,000	1,222,349,613
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,100,200,000	1,222,349,613
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,804,730	184,985,575.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,804,730	184,985,575.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,202,063	-
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	1,352,000	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,850,063	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	349,061,950	586,991,517
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	349,061,950	586,991,517

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

		Өмнөх оны	Тайлант оны
--	--	-----------	-------------

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,611,473,500	744,893,680	1,192,804,100	756,405,756.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,611,473,500	744,893,680	1,192,804,100	756,405,756.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	29,164,437	65,440,200	756,405,756.52
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,663,437	7,500,000	756,405,756.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,663,437	5,500,000	756,405,756.52
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			2,000,000	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	25,501,000	57,940,200	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,395,000	34,955,000	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		14,106,000	22,985,200	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,611,473,500	715,729,243	1,127,363,900	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,611,473,500	715,729,243	1,127,363,900	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,611,473,500	715,729,243	1,127,363,900	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,611,473,500	744,893,680	1,192,804,100	756,405,756.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,609,473,500	351,000,000	1,190,804,100	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,609,473,500	351,000,000	1,190,804,100	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000	393,893,680	2,000,000	756,405,756.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		349,061,950		574,085,180
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000	32,804,730	2,000,000	182,320,576.52
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		12,027,000		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	784,187,500	1,287,779,813
21	УРСГАЛ ЗАРДАЛ	784,187,500	1,287,779,813
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,137,437	61,440,200
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,137,437	61,440,200
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		61,440,200
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,137,437	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	769,050,063	1,226,339,613
2132	Бусад урсгал шилжүүлэг	769,050,063	1,226,339,613
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	751,200,000	1,226,339,613
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,850,063	-
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	17,850,063	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	784,187,500	1,287,779,813
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	784,187,500	1,287,779,813
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	32,987,500	61,440,200

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	751,200,000	1,226,339,613
--------	--	-------------	---------------

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналт, үндсэн хөрөнгө, төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 02 дугаар сарын 10-наас 2022 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Халамжаас Хөдөлмөрт -Халамж хүртэгчдийг хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлж хандлагыг нь өөрчлөх орлоготой болгох, амьжиргааг дээшлүүлэх” гэсэн зорилтыг үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Ажлын байрыг нэмэгдүүлэх, Imis программд бүртгэлтэй байгаа ажилгүй иргэдийг ажлын байранд түр болон бүрэн ажлын байранд зуучлах,*
- *Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, ажилд зуучлах, арга хандлагыг өөрчлөх,*
- *Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд залуу малчдыг мал маллах арга ухаанд суралцуулах,*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*
- *Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2021.02.91-ны өдрийн Цар тахлыг үед аж ахуйн нэгж эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт /малжуулах төсөл/*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсээс тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй,

байгууллагын захиргаа хяналт үнэлгээний хэлтсийн дотоод хяналт, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 2,059.8 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 30.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 23.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,679.8 сая төгрөгөөр болж 25.77 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Авлага оны эхэнд 2,652.0 сая төгрөг байсан бол оны эцэст 2,674.3 сая төгрөг болж 22.3 сая төгрөгөөр өссөн үүнээс 19.7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлын авлага, 2.6 сая төгрөгийн үндсэн данснаас зээлдэгчийн эргэн төлөлтийг орлогыг татан төвлөрүүлснээс нэмэгдсэн байна. Авлагын дансны үлдэгдлийн 2.6 хувь буюу 67.7 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн, 13.5 сая төгрөгийн 12 төсөл хэрэгжүүлэгч нь нас барсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5.5 сая төгрөг болж 3.5 сая төгрөгөөр нэмэгдэж тайлант онд 42.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 39.1 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Тайлант оны эхэнд 448.7 сая төгрөгийн өр төлбөртэй байсан бол оны эцэст өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2,205.4 сая төгрөг байсан оны эцэст 2,679.8 сая төгрөг тайлант онд 474.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн

247.7 сая төгрөг, өмнө оны авлагатай холбоотой 226.6 сая төгрөгөөр өмнөх үр дүн рүү залруулах бичилт хийгдсэнтэй хамааралтай байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,460.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3,460.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг 1,192.8 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 4 удаа төсвийг өөрчлөн баталж, ХХҮЕГ-ын 2021 оны 12 дугаар сарын 13-ны А/365 тоот тушаалаар 1,257.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор өөрчилсөн байна.

Төсөвт тодотгол хийн 1,192.8 сая төгрөгийн төсөв баталснаас 1,192.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ

Гүйцэтгэлээр зээлийн эргэн төлөлтөөс 576.7, ХБИ ажиллуулаагүй орлогоор 182.3 сая төгрөг, нийт 759.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, ХЭДС-ийн 100900037010 тоот дансанд 759.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайлангаар улсын төсвөөс 1,239.2, дэлхийн банкны орон нутгийн санаачилгын төсөлд 61.4 сая төгрөг нийт 1,300.7 сая төгрөгийн санхүүжилт авч оны эцэст 12.9 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлж 1,287.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулах шаардлагатай дараах асуудал байна.

ХЭДС-гаас 2014-2021 онуудад төсөл хөтөлбөрийн зээлдэгчдэд 4,392.1 сая төгрөгийн зээл олгогдсоноос 2021 онд 761 зээлдэгчийн 1,084.5 сая төгрөгийг зээл төлөгдөхөөс 424 иргэн аж ахуйн нэгжийн 576.5 сая төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлэн оны эцэст 337 зээлдэгчийн 507.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Өмнөх онд улсын төсвийн санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс 249 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд 448.7 сая төгрөгийн төсөл хөтөлбөрийн зээл болон үйл ажиллагааны зардлын өр төлбөрийг барагдуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, 4 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын зарим ажил гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулаагүй байна.

ХХҮЕГ-ын 1/1399 тоот албан бичгийн дагуу аймгийн ХХҮГ-ын хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн хяналт Шилэн дансны цахим хуудсанд дотоод хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 69.4 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 50 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ХЭДС-аас олгож байгаа төсөл хөтөлбөрийн сонголт шалгаруулалт, төслийн явц, үр дүн болон дотоод хяналт үнэлгээний хэрэгжилт, өмнөх оны 448.7 сая төгрөгийн үүссэн өр төлбөр, зээлдэгчдэд олгосон зээлийн авлага, Огторгуйн асар, Тээлийн долгион хэвлэл мэдээллийн байгууллагатай дахин гэрээ байгуулан төлбөр нэмж төлсөн асуудлыг нарийвчлан авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудлууд байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 124.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 46.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 2.8 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 36.4 сая төгрөгийн албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 39.6 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. ЕБС-ийн танхим тохижуулах зорилгоор олгосон 15.0 сая төгрөгийг нийлүүлэгч байгууллагад урьдчилан төлбөрийн шилжүүлсэн, уг ажил тайланд онд хийгдээгүй, зээлдэгч нарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад 4.7 сая нийт 19.7 сая төгрөгөөр санхүүгийн тайланд авлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй орхигдуулсан,
2. Тайлант үеийн үр дүнг 23.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 46.1 сая төгрөгийн залруулга хийсэн талаар 2022 оны 02

дүгээр сарын 25-ны 77 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Албан хаагчдад төсвийн хөрөнгөөр бал худалдан авч олгосон, хэвлэл телевизийн байгууллагад санхүүжилт илүү олгосон, шатахууны урамшууллыг бүртгээгүй 2.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн хуулийн заалт, аудитын “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 36.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар заасан ч сангийн хөрөнгөөр гарын авлага, брошур хэвлүүлэхэд 15.4 сая төгрөгийг зарцуулсан,
2. ХЭДС-аас сангийн үйл ажиллагааны болон хяналт хэрэгжүүлэх шатахууны төлбөрийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад 21.0 сая төгрөг шилжүүлэн эд хариуцагч нь шатахууны талоныг хүлээн авдаггүй шууд төсвийн захирагч, нягтлан бодогч нар авч зарцуулдаг зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага бичих

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ХЭДС-ийн эх үүсвэрээр борлуулалтын төвд худалдан авсан тоног төхөөрөмж, бусад хөрөнгө, пэж хуудас буюу биет бус хөрөнгийг 14.5 сая төгрөгөөр худалдан авч данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д " аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгийг данс бүртгэлд тусган ХХҮГ-ын санхүүгийн тайланд тусгах

4.4.2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХЭДС-ийн зээлд хамрагдаж төсөл хэрэгжүүлж байгаа зээлдэгч нь тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй, аудитын явцад түүвэрлэн утсаар холбогдон мэдээлэл авахад 17.0 сая төгрөгийн зээлдэгчид тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй байгаа нь сангийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна.

Энэ нь Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн гэрээний 4.5-д "Б тал энэхүү гэрээний дагуу олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалт бусаар зарцуулсан, бусдад дамжуулсан, ашиглуулсан, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд А талд учруулсан хохирол (шүүхийн зардал, үндэсний аудитын байгууллагын акт, улсын байцаагчийн албан шаардлага, актаар тогтоогдсон) олгосон санхүүгийн дэмжлэгийг эргүүлж нөхөн төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Нийт олгосон зээлийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн зээлийг зориулалт бусаар зарцуулсан, орон нутагт үйл ажиллагаа явуулахгүй байгаа иргэдийн зээлийг буцаан сангийн дансанд төвлөрүүлэн ажиллах

4.4.3 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХҮГ-ын дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн нь тайлант онд хийгдсэн хяналт үнэлгээ ажил үр дүнгүй, хангалтгүй, холбогдох мэргэжилтнүүд төсөл хөтөлбөрт хамрагдсан зээлдэгч нар руугаа утсаар хяналтын баг танай төслийн үйл явцад төслийн хэрэгжилтэд хяналт хийх талаар урьдчилан мэдээлэл өгч төсөлд заасны дагуу бэлтгэл хангуулдаг, хяналтын баг зээлдэгч бүртэй тулж ажилладаггүй, зээлд хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэний төсөлтэй танилцахдаа үйл ажиллагаагаа явуулж байгаа ажлын байр нь тухайн иргэний өөрийн өмч эсэх, түрээсэлж байгаа эсэхийг нотлохгүйгээр зээл олгодог зөрчил нийтлэг байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 3.2-д " дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн, байгууллагын удирдлагад захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус" Зээлдэгчийн гэрээний 4.8-д "Б тал олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хуваарийг зөрчсөн тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги хоног тутамд А талд төлөх үүрэгтэй" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналт үнэлгээний баг төсөл сонгон шалгаруулалтыг бодитой үнэлэх, хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх,

4.4.4 Хэвлэл мэдээллийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Огторгуйн асар, Тээлийн долгион хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай нэмэлт гэрээ байгуулан 8.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх 2 байгууллагын дутуу хэрэгжүүлсэн ажлуудыг дахин хийлгэн төсвийн хөрөнгө оруулалтын ажлын үр дүнг сайжруулан ажиллах, 2022 онд төсвөөс дахин санхүүжилт олгохгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	8	124.9	3	46.1	1	2.8	1	36.4	4	39.6

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АХЛАХ АУДИТОР:

Д.НАРАНТУУЛ